



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/132

Улаанбаатар хот


**Баянзүрх дүүргийн 172 дугаар  
цэцэрлэгийн данс бүртгэлд  
хөрөнгө бүртгэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 3,471,900.0 /гурван сая дөрвөн зуун далан нэгэн мянга есөн зуу/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Баянзүрх дүүргийн 172 дугаар цэцэрлэг /З.Болормаа/-т зөвшөөрсүгэй.


2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянзүрх дүүргийн 172 дугаар цэцэрлэг /З.Болормаа/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
газрын даргын 2019 оны 02 сарын  
09 өдрийн 5/252 дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 172 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт, хүчин чадал	Ашиглалтанд ороон	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
<b>Машин, тоног төхөөрөмж</b>											
1	Тоос сорогч	Eiko SM16HD		2019	Сайн	ш	1	159,900.00	159,900.00	Эцэг эх	Хандив
2	Өнгөт принтер	Epson L360		2019	Сайн	ш	1	348,000.00	348,000.00	Эцэг эх	Хандив
3	Халаалтын тень	1600	Хятад	2019	Сайн	ш	2	200,000.00	400,000.00	Эцэг эх	Хандив
4	Зурагт	LG	42 инч	2019	Сайн	ш	1	450,000.00	450,000.00	Эцэг эх	Хандив
5	Өсгөгч фульт	PMX-602		2019	Сайн	ш	1	534,000.00	534,000.00	Эцэг эх	Хандив
6	Явуулын өсгөгч	TEMEISH EN G	1200W	2019	Сайн	ш	1	160,000.00	160,000.00	Эцэг эх	Хандив
7	Өнгөт принтер	Epson L360		2019	Сайн	ш	1	440,000.00	440,000.00	Эцэг эх	Хандив
<b>Машин, тоног төхөөрөмжийн дүн</b>							<b>8</b>		<b>2,491,900.00</b>		
<b>Тавилга, эд хогшил</b>											
8	Хүүхдийн модон ширээ /жижиг/		Модон	2019	Сайн	ш	10	50,000.00	500,000.00	Эцэг эх	Хандив
9	Хүүхдийн модон ширээ		Модон	2019	Сайн	ш	8	60,000.00	480,000.00	Эцэг эх	Хандив
<b>Тавилга, эд хогшлын дүн</b>							<b>18</b>		<b>980,000.00</b>		
<b>Нийт хөрөнгийн дүн</b>									<b>3,471,900.00</b>		